

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН МӨРДӨГЧИЙН АЖИЛ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ.

Д.Бямбабат

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8011 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн хошууч

Товч агуулга: Цагдаагийн байгууллагын мөрдөгчийн ажлын үр дүнг үнэлж буй өнөөгийн шалгуур үзүүлэлт бодит байдалтай хэрхэн нийцэж, хүний хийсэн ажил, хөдөлмөрийг шударгаар үнэлж, дүгнэж, урамшуулах, шийтгэх үүргээ хэрэгжүүлж чадаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон.

Түрхүүр үг: Цагдаагийн байгууллагын мөрдөх чиг үүрэг, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөгч, ажлын үзүүлэлт, үр дүн.

Abstract: Police detective It was intended to provide an evaluation and conclusion on how the current criteria for assessing work results are in line with reality, and whether the work and labor done by a person can be fairly assessed and evaluated, and the role of rewarding and punishing can be implemented.

Key words: Police investigative functions, investigative bodies, investigative procedures, detectives, work indicators and results.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хүний нөөцийн нэг томоохон функц бол ажилтны ажил дүгнэх буюу ажлын гүйцэтгэлийг үнэлэх асуудал байдаг. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ гэдэг нь байгууллагын зүгээс ажилтан бүрд өөрт ногдсон үүрэг даалгавраа хэрхэн биелүүлж, ямар үр дүнд хүрч байгаа түүний үр чадвар, мэргэшлийн бэлтгэл, ажлын ачаалал ямар байгааг дүгнэх үйл явц юм⁷⁸.

Байгууллага өөрийн хүний нөөц, ажиллах хүчээ үнэлэх, дүгнэх замаар өөрийн байгууллагын ажлын гүйцэтгэлийн талаарх бодит

мэдээлэлтэй болохоос гадна алба хаагчдаа шагнаж урамшуулах, дэвшүүлэх эсрэгээрээ сахилгын шийтгэл оногдуулах, халах, албан тушаал бууруулах гол үндэслэл болдог.

Миний бие 2010 оноос мөрдөх чиг үүргийг хэрэгжүүлж, 2014 оноос мөрдөн байцаах нэгжид ажиллаж ирсэн. Мөрдөгч албан тушаалын жаргал, зовлонг биеэр үзэж туулж, мэдэрсэн хүний хувьд ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, тухайн мөрдөгчийн хэрэгжүүлсэн ажлыг шударгаар үнэлж, дүгнэх нь чухал гэж ойлгож явдаг. Цагдаагийн албаны тухай хуулийн 3 дугаар

⁷⁸ Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний тухай. Цахим эх суриалж: (hrconsulting.mn)

зүйлийн 3.1.1-д "гэмт хэрэгтэй тэмцэх" гэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулахын ойлгоно гэж хуульчилсан⁷⁹.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект нь мөрдөгч нар юм. Харин мөрдөгч гэж хэнийг хэлэх вэ? Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.8-д "Мөрдөгч" гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтныг хэлнэ⁸⁰, мөн хуулийн 1.9-д "Мөрдөн шалгах ажиллагаа" гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын зөвшөөрлөөр, эсхүл мөрдөгч бие даан явуулах энэ хуульд заасан ажиллагааг, "Мөрдөн шалгах нууц ажиллагаа" гэж прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах энэ хуульд заасан ажиллагааг, "Мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга" гэж мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах нэгжийн даргыг, "Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага" гэж энэ хуульд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар заасан байгууллагыг хэлнэ гэж тус тус тодорхойлсон.

Мөрдөгчийн хэрэг шалгах дараалал, үйл ажиллагаа бүхнийг хуульчилж, журамлаж өгсөн.

Өөрөөр хэлбэл хууль, журмаас гадуур нэг ч үйл ажиллагаа явагддаггүй гэж хэлэхэд хилсдэхгүй байх. Мөрдөгчийн эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар энэ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахаас гадна мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал прокурорт гаргах, сэжигтнийг баривчлах, хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагааг явуулах саналыг прокурорт гаргах, прокурорын зөвшөөрөл авахаар хуульд зааснаас бусад тохиолдолд гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, олж тогтоох мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулах, гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчийг дуудан ирүүлэх, шинжилгээ хийлгэхээр шинжээч томилох, таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох, шүүх, прокурор авахаар хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох, өөрчлөх тухай саналыг прокурорт гаргах, сэжигтнийг баривчлах шүүхийн

⁷⁹ Цагдаагийн албаны тухай хууль.

⁸⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.

зөвшөөрөл авах тухай саналыг прокурорт гаргах, оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх, прокурорын даалгавраар мөрдөн шалгах ажиллагаа явуулах, даалгаврыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт саналаа бичгээр нэг удаа гаргах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл 5 хоногийн дотор дээд шатны прокурорт бичгээр санал гаргах, прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулахаар эрх бүхий байгууллагад даалгавар бичиж, гүйцэтгүүлэх, өөр нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлах шаардлага гарвал энэ тухай даалгаврыг бичгээр хүргүүлэх ба түүнийг хүлээн авсан мөрдөн шалгах байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар ирүүлэх, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлах, мөрдөн шалгах ажиллагааг харьяаллын бус мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагаар хийлгэх шаардлага гарвал мөрдөгч энэ тухай саналаа прокурорт гаргана. Прокурорын даалгаврыг хүлээн авсан тухайн мөрдөн шалгах ажиллагааг явуулах

байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамт прокурорт хүргүүлэх, гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох талаар энэ хуульд заасан ажиллагаа явуулах, тусгай мэдлэг эзэмшсэн мөрдөгч энэ хуульд заасан шинжээчийн эрхийг хэрэгжүүлж, магадалгаа гаргах, шинжилгээ хийлгэхээр томилогдсон шинжээчтэй хамтран ажиллах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэх зэрэг эрхийг хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий мөрдөгчийн ажлыг хэрхэн, ямар арга, аргачлалаар үнэлж, дүгнэж байгааг авч үзвэл:

Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны даргын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 тушаалаар Мөрдөн байцаах албаны 2023 оны хүрэх түвшин, нэгжийн болон алба хаагчийн ажлыг дүгнэж, үнэлэх шалгуур үзүүлэлтийг баталсан байна. Уг тушаалын нэгдүгээр хавсралтаар мөрдөн шалгах ажиллагааны ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, нэгж болон мөрдөгчийн ажлыг бодитой үнэлж, дүгнэх зорилгоор мөрдөн байцаах албаны 2023 оны хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг баталж, хоёрдугаар хавсралтаар нэгжийн болон алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт,

хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг тус тус баталсан байна. Энд дурдсанаар мөрдөн байцаах албаны 2023 оны хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг 12 төрлөөр гаргажээ. Тухайлбал: шүүхэд шилжүүлсэн хэргийн 100 хувьд гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгахаар мэдэгдэл бичиж, хариуг 100 хувь авсан байна, олны анхаарал татсан, ээдрээ төвөгтэй, олон үйлдэл холбогдогчтой хэрэгт 100 хувь, нийт мөрдсөн хэргийн 50-аас дээш хувьд даргын зааварчилгаа бичиж, биелэлт үр дүнг тооцсон байна, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 60-аас доошгүй хувийг нөхөн төлүүлсэн байх, хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн илрүүлэлтийг 90 хувь, шийдвэрлэлтийг 85 хувьд хүргэх гэх мэт хүрэх түвшингээ тодорхойлжээ⁸¹.

Харин тухайн мөрдөгчийн ажлыг дүгнэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалд нэгжийн болон алба хаагчийн ажлыг тус албаны дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтэс улирал, хагас бүтэн жилээр хяналт шинжилгээ хийнэ, тэргүүний шилдэг, онцлох алба хаагч, хамт олны шалгаруултад Нийслэлийн цагдаагийн удирдах газар, эрүүгийн цагдаагийн алба, тээврийн цагдаагийн алба, аймаг, дүүргийн

цагдаагийн газар, хэлтсийн мөрдөн байцаах тасаг, хэсгийн бие бүрэлдэхүүн хамрагдана гэж тусгажээ.

Тэргүүний болон шилдэг алба хаагч шалгаруулах журмыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам⁸² код 133-аар зохицуулсан байна.

Алба хаагчдын ажлыг дүгнэхдээ тухайн онд ажилласан хоног, илрүүлсэн болон шийдвэрлэсэн хэрэг, бүх төрлийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байдал, хөтлөгдвөл зохих бүртгэл судалгаа, шалгах төлөвлөгөөний баяжилт, сахилга, хариуцлагын байдал, ажлын шинэлэг, дэвшилтэт арга, туршлага, санал, санаачилга гаргаж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн зэргийг харгалзах үзүүлэлт болгон эрэмбэлж байр эзлүүлнэ⁸³ гэж тусгажээ.

Нэг мөрдөгчийн нэг жилд ажиллах хоногийг дунджаар гаргаж, түүний ажил, ачаалал, хийгдсэн ажил шударгаар үнэлэгдэж байгаа эсэхэд дүгнэлт хийж үзье. Тухайлбал: Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах газрын Мөрдөн шалгах хэлтсийн нэг мөрдөгчийн ажлын ачааллаар жишээ авъя. Энэ хэлтэс батлагдсан орон тоогоор хэлтсийн дарга-1, чиглэлийн ахлах мөрдөгч-1, ахлах

⁸¹ ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны даргын 2023 оны А/01 тушаал.

⁸² Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 133.

⁸³ ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны даргын 2023 оны А/01 тушаалын хоёрдугаар хавсралт.

мөрдөгч-14, мөрдөгч-6 нийт 22 орон тоотойгоор нийслэлийн хэмжээнд зам тээврийн осолд өртөж хүний амь нас, эрүүл мэнд хохирсон гэмт хэргийн дуудлага, мэдээлэл, хэргийг шийдвэрлэн ажилладаг. Хэлтсийн дарга, чиглэлийн ахлах мөрдөгч нар хэрэг шалгах ажиллагаанд оролцохгүй, удирдан зохион байгуулах үүрэгтэй, тухайн хэлтэст ирсэн, явсан бичгийн эргэлтэд хяналт тавих зорилгоор 1 ахлах мөрдөгч мөн хэрэг шалгахгүй, алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого хэрэгжихгүй болохоор жил тойрон байнгын 2-3 орон тоо дутуу үүрэг гүйцэтгэнэ. Ингээд бодохоор 16 алба хаагч бүтэн жилийн туршид ажиллана гэж ойлгож болно. Үүнээс 1 мөрдөгчийн ажлын ачааллыг аваад үзье. Мөрдөгч нар тойргийн системээр жижүүрт 24 цагаар ажиллаж, тухайн өдрийн нийслэл хотод бүртгэгдсэн зам тээврийн ослын дуудлагад ажиллана. Жилд 365 хоногтой, 30 хоног ээлжийн амралттай байна гэж үзвэл 335 хоногт 16 мөрдөгч 2, 2-оороо жижүүрийн шуурхай бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэдэг гэж тооцвол 8 хоногт 1 удаа жижүүрт гарах хуваарьтай, жилд 1 мөрдөгч 41 удаа 24 цагаар үүрэг гүйцэтгэнэ гэсэн үг. 1 жижүүрт гарахад 7-8 дуудлага, мэдээлэлд хойшлуулшгүй ажиллагаа явуулдаг гэсэн үг. Осол хаана үйлдэгдсэн, шалтгаан нөхцөлийг тогтоох, эзэн

холбогдогчийг олох, хохирогчийг хамгаалах гэх мэт мөрдөн шалгах ажиллагааг явуулсан байна. Хоногт хүлээж авсан 8 дуудлага, мэдээллээс 2-3 гомдол эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 4-5 гомдлыг зөрчил гэж үзэж шийдвэрлэх тохиолдол байна. Энэ тооцооллоор 3 эрүүгийн хэргийг 41 хоногоор үржүүлэхэд хамгийн ихдээ 1 мөрдөгч жилд 120 орчим хэргийг хагас жилд 60, улиралд 30, сард 10, 3 өдөр тутамд 1 хэргийг шүүхээр шийдвэрлүүлсэн байхаар тооцогдож байна. Хэрэг шийдвэрлэхээс гадна нэгдсэн хамгаалалтад ажиллах, улсын хэмжээнд зохион байгуулагдах ерөнхий болон тусгай арга хэмжээнд үүрэг гүйцэтгэх гэх мэтчилэн ажлыг оруулаагүй.

Цагдаагийн ерөнхий газрын Мөрлөн байцаах албаны дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтсээс нийслэлийн хэмжээнд 2022 онд ажилласан 530 мөрдөгчийн ажлын үзүүлэлтийг дүгнэж, байр эзлүүлэн жагсаалттай танилцахад Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч С.Өлзийбаяр⁸⁴ 259 гомдол, мэдээлэл шалшаж, 427 эрүүгийн хэрэг шийдвэрлэснээс 206 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 181 хэргийг хэрэгсэхгүй болгож, 40 хэргийг нэгтгэсэн үзүүлэлтээр

⁸⁴ ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны 2022 оны тайлан, мэдээ

нийслэлийн хэмжээнд тэргүүн байр эзэлжээ. Бүтэн нэг жилд 53 долоо хоног байдаг, зөвхөн амралтын 106, бүх нийтийн баяр, амралтын 10 өдрийг хасвал 249 ажлын өдөртэй байсан гэж тооцъё. Тэргүүн байр эзэлсэн мөрдөгч өдөр бүр 2 эрүүгийн хэрэг, 1 гомдолтой шийдвэрлэж ажилласан байна. Энгийн логикоор бодвол тэргүүн байр эзэлсэн мөрдөгч ээлжийн амралт, чөлөө, зөвшөөрөл нэг ч удаа аваагүй бүтэн жил ажилласан гэж тооцоход өдөр бүр 2 хэрэг, 1 гомдолтой шийдэх боломжтой эсэхэд эргэлзмээр санагдаж байна уу? 7-8 хүний хийх ажлыг нэг алба хаагч хэрэгжүүлж ажилласан гэхэд хэцүүхэн дүгнэлт гарна. Мэдээллийн санд мөрдөгч А 1+1+1+.... хэдэн ч хэрэг шийдвэрлэсэн гэж шивж болно. Ингэхээр тухай мөрдөх чиг үүргийг хэрэгжүүлж буй нэгжийн даргын үзэмжээр ажил дүгнэгдээд байна уу гэдэг хардлага төрөх нь ойлгомжтой юм. Нэг эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд хамгийн багадаа 50 хуудас материал бүрдүүлэх шаардлагатай, ганцхан мөрдөгчөөс биш өөр олон байгууллага хамтарч хэрэг шийдвэрлэгддэг.

Ажил дүгнэсэн энэ жагсаалтаас өөр нэг дүгнэлт хийвэл 530 алба хаагчаас гарын арван хуруунд багтахгаар алба хаагчид 200-аас дээш эрүүгийн хэрэг шийдвэрлэжээ. Нийт мөрдөгчдийн 75,4 хувь нь 50-аас доош хэрэг шийдвэрлэжээ.

Дүгнэлт.

Шударга бус байдлаар ажил нь дүгнэгдээд байхаар дундуур, доогуур байр эзэлсэн ч хийх ёстой ажлаа хийгээд ажиллаж байгаа мөрдөгчид ажлаараа түрүүлнэ гэдэг үлгэрт гардагтай адил мөрөөдөөд ч хэрэггүй зүйл болон хувирч, ажлаасаа халшрах, төвөгшөөх, цаашлаад орхих шийдвэрт хүрч байж болзошгүй гэж судлаач би дүгнэж байна.

Шалгасан гомдол, мэдээлэл, татгалзсан, харьяаллын дагуу шилжүүлсэн гэх мэтчилэн шийдвэрүүд мөрдөгчийн ажлыг дүгнэх үзүүлэлтэд тусгагдаагүй байгаа нь өрөөсгөл юм. Өөрөөр хэлбэл өдөрт хийж байгаа ажлын 80 орчим хувь н энэ ажлыг хэрэгжүүлэхэд өөрөөр хэлбэл хүлээн авсан гомдол, мэдээллийг шалгах, шийдвэрлэх ажиллагаанд орж байна. Гэтэл тухайн алба хаагчийн хийсэн ажлын 80 орчим хувь нь үнэлэгдэхгүй өнгөрч, шударга бусаар, нэгнийхээ хийсэн ажлыг нэмж нэгтгээд өрсөлдөж, түрүүлэх, дээгүүр байр эзлэх энэ байдал нь энгийн нэг мөрдөгч албандаа итгэл үнэмшилгүй болох, хэрэгжүүлж буй ажлаа шударгаар үнэлүүлж чадахгүй байгаа байдалд сэтгэл гутрах тохиолдол их байгаа нь нууцгүй үнэн юм.

Санал.

Мөрдөгчийн ажлыг үнэлэх, дүгнэх чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мөрдөгчийн шалгасан эрүүгийн хэргийг тоолохоос гадна шалгаж, шийдвэрлэсэн гомдол,

мэдээллийг тоолж, ажил дүгнэх үзүүлэлтэд тусгах.

2. Мөрдөгч нар хоорондоо шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлэх, 5 мөрдөгчийн хийсэн ажлыг нэг мөрдөгч хэрэгжүүлсэн мэтээр санд бүртгэж, үнэлж, дүгнэдэг, уралдуулдаг системийг өөрчлөх. Яг одоогийн ажил дүгэх аргачлал бол зөвхөн тухайн мөрдөх чиг үүргийг хэрэгжүүлж буй нэгжийн даргын үзэмж, үнэлэмжээр шийдвэрлэгдэж байна. Бодитойгоор үнэлж, дүгнэдэг байх.

3. Ажил үүргийн хуваарийн дагуу ажлаа хэрэгжүүлсэн эсэхэд хяналт шалгалт хийдэг байх, өөрөөр хэлбэл тухайн мөрдөн байцаах тасаг, хэсгийн дарга нарын хэрэгжүүлбэл зохих ажлыг тухайн нэгжийн мөрдөгч нар өөрсдийн хэрэгжүүлэх ажил дээрээ нэмэлт

байдлаар хэрэгжүүлсээр ирсэн. Ажлын байрны тодорхойлолтод заасан тус тусын чиг үүргийг хэрэгжүүлдэг байх, үүнд тавих хяналтын системийг боловсронгуй болгох зэрэг саналыг судлаачийн зүгээс дэвшүүлсэн болно.

Ашигласан эх сурвалж.

1. Төрийн албаны тухай хууль.
2. Цагдаагийн албаны тухай хууль.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.
4. Мөрдөн байцаах албаны даргын 2023 оны А/01 тушаал.
5. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 133
6. www.murdunbaitsaah.alba.police.gov.mn сайт